

Монгол Улсын 2027 төсвийн хөрөнгө оруулалтын шилжих төслүүдийн төсөвт өртөгт дүн шинжилгээ хийх ажлын даалгавар

2026 оны 9 дүгээр сар

1. Үндэслэл

Монгол Улсын төсөв өндөр хэмжээний алдагдалтай байгаа энэ үед төсвийн хөрөнгийн зарцуулалтын үр ашгийг дээшлүүлэх асуудал хурцаар тавигдаж байна. Сүүлийн жилүүдэд төсвийн хөрөнгө оруулалтын өмнөх оноос шилжин ирж буй төслүүдийн төсөвт өртөг ихээхэн нэмэгдэж байгаа нь ажиглагдаж байна. 2027 оны улсын төсвийн төсөл УИХ-д өргөн баригдаад байна. Иймд хөрөнгө оруулалтын төслүүдийн төсөвт өртгийн өөрчлөлтийг судалж, анхаарах шаардлагатай асуудлуудыг олон нийтийн анхааралд оруулах, УИХ-д санал, дүгнэлт хүргүүлэх нь чухал байна.

2. Судалгааны ажлын зорилго

Энэхүү судалгаа нь Засгийн газраас 2027 онд улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр УИХ-д өргөн барьсан болон батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт дахь өмнөх оноос шилжин ирсэн төслүүдийн төсөвт өртгийн өөрчлөлтийг судалж асуудал дэвшүүлэх зорилготой.

3. Гүйцэтгэх ажил

Зөвлөх нь Засгийн газраас 2027 онд улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр УИХ-д өргөн барьсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт дахь өмнөх онуудад эхэлсэн шилжих төслүүдийг хамруулан судалгаа хийхээс гадна УИХ-д өргөн барьсан болон УИХ-аас баталсан хөрөнгө оруулалтын төслүүдийн төсөвт өртгийг харьцуулж судлах юм. Зөвлөх нь дараах хүрээнд дүн шинжилгээ хийж, түүнийгээ хэлэлцүүлэг, уулзалтад танилцуулах ажил гүйцэтгэнэ:

3.1. 2027 онд улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр УИХ-д өргөн барьсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн шилжих төслүүдийн судалгаа хийнэ. Үүнд дараах асуудлуудыг хамруулна:

- i. Хөрөнгө оруулалтын шилжих төслүүдийн анх төлөвлөсөн эхлэх болон дуусах хугацаа өөрчлөгдсөн эсэх, төслүүдийн төсөвт өртөгт өөрчлөлт орсон эсэхийг судлах;
- ii. Төсөвт өртөг нь өөрчлөгдсөн 3-4 төслийг сонгон уг өөрчлөлтөд хүргэсэн байж болох шалтгааныг судлах.

3.2. УИХ-аас 2027 оны төсвийг батлахдаа Засгийн газраас өргөн барьсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн төсөвт өртөгт өөрчлөлт оруулсан эсэхийг судалж, дүгнэлт бичих юм.

4. Зорилтот хэрэглэгчид

Судалгааны дүнгийн зорилтот хэрэглэгчид нь бодлого боловсруулагчид болон олон нийт, иргэний нийгэм байна.

5. Хүлээлгэж өгөх бүтээгдэхүүн:

Ажил гүйцэтгэгч нь дараах бүтээгдэхүүнүүдийг хуваарьт заасны дагуу ННФ-д хүлээлгэж өгнө. Үүнд:

	Бүтээгдэхүүн	Хугацаа
1	2027 онд улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр УИХ-д өргөн барьсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн шилжих төслүүдийн төсөвт өртгийн судалгааны эхний тайланг ННФ-д ирүүлэх	2026 оны 10-р сарын 13-ний дотор
2	Дээрх судалгааны дүнг нийтэд танилцуулах	2026 оны 10-р сарын 22-ны дотор
3	Дээрх судалгааны эцсийн тайланг ННФ-д ирүүлэх	2026 оны 10-р сарын 25-ний дотор
4	УИХ-аас баталсан 2027 оны хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн төсөвт өртгийн өөрчлөлтийг өргөн баригдсан төсөлтэй харьцуулсан судалгааны эхний тайланг ННФ-д ирүүлэх	2026 оны 11-р сарын 24-ний дотор
5	2026 онд төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр батлагдсан хөрөнгө оруулалтын шилжих төслүүдийн төсөвт өртгийн судалгааны эцсийн тайланг ННФ-д ирүүлэх	2026 оны 11-р сарын 30-ны дотор

6. Мэдээллийн эх сурвалж

Судалгааг хийхдээ дор дурдсан болон бусад холбогдох баримт бичгүүдийг ашиглана. Үүнд:

- Засгийн газраас УИХ-д өргөн барьсан 2027 оны төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт
- 2020-2027 онд улсын төсвөөс санхүүжихээр батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт
- Монгол Улсын 2027 оны төсвийн төслийн баримт бичиг (дэлгэрэнгүй танилцуулга, тооцоолол) болон өмнөх онуудын төсвийн гүйцэтгэлийн тайлангууд дахь төсвийн хөрөнгө оруулалтын талаарх мэдээллүүд
- Төсвийн мэдээллийн холбогдох цахим хуудаснууд
- Төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын холбогдох хууль, тогтоомжууд
- Холбогдох төрийн байгууллагууд (Сангийн яам, Хөрөнгө оруулалтын газар, Худалдан авах ажиллагааны газар гэх мэт)
- Бусад эх сурвалжууд

7. Ажил гүйцэтгэх хугацаа:

Ажлын удирдамжийн 3-р зүйлд заасан ажлуудыг 2026 оны 10-р сарын 1-нээс 11-р сарын 30-ны хооронд гүйцэтгэнэ.

Судалгааны ажлын төсөв:

Судалгааны хүрээнээс хамаарч судалгааны төсвийн дээд хязгаар 6 сая төгрөг байна.

Зөвлөх нь Нээлттэй нийгэм форумтай нягт хамтран ажиллах ба судалгааны бүтээгдхүүнүүдийг 5-р зүйлд заасан хуваарийн дагуу ирүүлнэ.

8. Судалгааны ажилд тавигдах бусад шаардлага, хэмжээ, хэлбэр

Гэрээт ажилд ашигласан дагалдах материал, судалгааны эх бичвэрийн файл, цахим хуудас зэргийн жагсаалтыг ажлын гүйцэтгэлд хавсаргана.